



## Албан хаагчид орон нутагт ажиллахаар замд гарлаа

Авлигатай тэмцэх газрын албан хаагчид 7 чиглэлд хуваагдан 21 аймагт ажиллахаар өнөөдөр замд гарлаа.

Авлигатай тэмцэх газрын ажлын хэсгүүд 2017 оны 10 дугаар сарын 29-нөөс эхлэн 11 дүгээр сарын 24-ний өдрийг хүртэлх хугацаанд орон нутагт ажиллахдаа аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дэргэд ажиллах “Авлигаас урьдчилан сэргийлэх Олон нийтийн дэд зөвлөл”-ийн гишүүдтэй гэрээ байгуулж, үйл ажиллагааг нь эхлүүлэх, орон нутгийн төрийн байгууллагуудын авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг газар дээр нь шалган туслах, авлигын нөхцөл байдлыг тодорхойлох юм.

Түүнчлэн холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, үйл ажиллагаа, баримт, материал, хүний нөөцийн бодлогын хэрэгжилт, албан тушаалын томилгоо, төрийн үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдал, тухайн байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийн тоо, тэдгээрийн агуулга, шийдвэрлэлт, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц байдал, Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн албан бичиг, мөрдөн байцаагчийн мэдэгдэл, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээтэй танилцаж судлан, санал дүгнэлт боловсруулна.

### ҮЙЛ ЯВДАЛ

## ХЭЛТЭС, АЛБАДЫН ДАРГА НАР МЭДЭЭЛЭЛ ХИЙВ



**2017 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хэвлэлийн бага хуралд Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Т.Баярхүү, Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Х.Хашбаатар, Мөрдөн байцаах албаны дарга, ахлах комиссар Н.Дамдинсүрэн нарын хийсэн мэдээллийг танилцуулъя.**

### **Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Т.Баярхүүгийн хийсэн мэдээлэл**

Олон нийтийн төвд авлига-хүнд суртлыг мэдээлэх 18001969 дугаарын утсыг тогтмол ажиллуулж, иргэд, олон нийтээс авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчил, хүнд суртал, чирэгдлийн талаар гомдол мэдээлэл хүлээн авч, шийдвэрлэлтийн талаар иргэдэд эргэн мэдээлж эргэх холбоотой ажиллаж байна. Түүнчлэн уг утсаар хандаж байгаа иргэдэд хуульзүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлж байна. Энэ сард нийт 69 дуудлага хүлээн авснаас 38-ыг нь гомдлоор хүлээн авч, 31 иргэнд хууль эрх зүйн зөвлөгөө, лавлагаа өгсөн байна. Агуулгын хувьд авч үзвэл дурдсан хугацаанд боловсролын салбартай холбоотой 15, Иргэдийн төлөөлөлөгчдийн хурал, Засаг даргын үйл ажиллагаатай холбоотой 9, нийгмийн даатгал, мэргэжлийн хяналт, газрын алба, гааль, цагдаа зэрэг бусад салбартай холбоотой 14 гомдол, мэдээлэл иргэдээс ирсэн байна.

Төгсгөл нь III нүүрт

## МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

### Ахмадууддаа хүндэтгэл үзүүллээ



Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар Х.Энхжаргал, дэд дарга, эрхэлсэн комиссар Ц.Нямдорж, Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар З.Баасанням нар тус газраас өндөр насны тэтгэвэртээ гарсан ахмадуудаа өнөөдөр хүлээн авч уулзав.

Тус газарт үр бүтээлтэй, идэвх зүтгэлтэй ажиллаж, гавьяаныхаа амралтыг эдэлж байгаа Ч.Сангарагчаа, Л.Доржсүрэн, Д.Цоодолсэнгээ, Б.Отгон, Ц.Бурмаа, Т.Отгонжаргал, Д.Мөнхжаргал, Д.Батмөнх нарт Олон улсын ахмадын баярын өдрийг тохиолдуулан хүндэтгэл үзүүллээ. Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар Х.Энхжаргал “Авлигатай тэмцэх байгууллагын зөвхөн өнгөрсөн цаг хугацаа биш ирэх цаг өдрүүд нь ч та бүхэнтэй салшгүй холбоотой. Ахмадуудын маань үлгэр дуурайл, туршлага сургамж нь залуу үедээ уламжлагдан явж байгаа” гэж хэлээд шинээр байгуулагдсан “Олон нийтийн төв”-ийн үйл ажиллагаатай танилцуулав.

Ахмадууд “Ахмадын хороо” байгуулж, тус газрын даргаар 2007-2011 онд ажиллаж байсан Ч.Сангарагчааг хорооны даргаар сонгосон болохоо Авлигатай тэмцэх газрын удирдлагад танилцууллаа.

### Нийтийн албан тушаалтнуудад Зөвлөмж хүргүүлэв

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд 2017 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсоноор хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргадаг албан тушаалтан тэдгээрийн хамаарал бүхий этгээд нь тухайн албан тушаалтны албан үүрэг гүйцэтгэх хугацаанд оффшор бүсэд өөрийн нэр дээр банкны данс нээлгэх, мөнгөн хөрөнгө байршуулах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулах буюу оффшор данстай байх, гадаадад өмчтэй байхыг хориглосон эрх зүйн шинэ зохицуулалт үйлчилж эхлээд байна.

Уг хуулийн 101 дүгээр зүйлийн 101.3 дахь хэсэгт заасны дагуу олон улсын эдийн засаг, банк, санхүүгийн байгууллагаас гаргасан жагсаалтыг харгалзан Монголбанк, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газраас оффшор бүсэд хамаарах нийт 49 нутаг дэвсгэрийн жагсаалтыг баталсан 2017 оны 8

дугаар сарын 31-ний өдрийн тогтоолыг баталгаажуулан 2017 оны 10 дугаар сарын 03-ны өдөр Авлигатай тэмцэх газарт албан ёсоор ирүүлээ.

Жагсаалтад Барбадос улс, Бахамын арлууд, Британийн Виржинийн арлууд, Кайманы арлууд зэрэг нийт 49 нутаг, дэвсгэр багтсан бөгөөд мэдүүлэг гаргагч тэдгээрийн хамаарал бүхий этгээд нь уг оффшор бүсэд хамаарах нутаг дэвсгэрт данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулсан тохиолдолд 3 сарын дотор нээлгэсэн банкны дансаа хаалгах, банкинд байршуулсан мөнгөн хөрөнгөө татах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг худалдах, шилжүүлэх, татах, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулсан бол үйл ажиллагаагаа зогсоох, эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ худалдах, шилжүүлэх, дуусгавар болгох арга хэмжээг авч, хөрөнгө, орлогын мэдүүлэгт орсон нэмэлт, өөрчлөлтийн талаар 30 хоногийн дотор Авлигатай тэмцэх газарт мэдэгдэж, шинэчлэн бүртгүүлэх үүрэгтэй байна.

Дээрх жагсаалтад багтсан нутаг дэвсгэрт суралцах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах зорилгоор тухайн улсын банкинд данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн бол Авлигатай тэмцэх газарт тухай бүрт бичгээр заавал мэдэгдэх бөгөөд уг хуулийн хэрэгжилтийн талаар тус газраас холбогдох байгууллагуудад зөвлөмж, чиглэл хүргүүлээд байна.

### Томоохон албан тушаалтнуудад холбогдох эрүүгийн хэргүүдийг прокурорт шилжүүллээ

Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсээс зарим эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын ажиллагааг дуусгаж, шүүхэд шилжүүлэх саналтайгаар прокурорын байгууллагад хүргүүллээ.

Орон сууцны санхүүжилтийн корпорацийн захирлаар ажиллаж байсан А.Гантулгад холбогдох эрүүгийн хэргийг, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Р.Эрдэнэбүрэн нарт холбогдох эрүүгийн хэргийг, Хөгжлийн банкны гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан Н.Мөнхбат нарт холбогдох эрүүгийн хэргийг, Гаалийн ерөнхий газрын Төрийн захиргаа, хамтын ажиллагааны газрын дарга Б.Оюундэлгэр нарт холбогдох эрүүгийн хэргийг, Зам тээврийн яамны газрын даргаар ажиллаж байсан Р.Онон нарт холбогдох эрүүгийн хэргүүдийг шүүхэд шилжүүлэх саналтайгаар харьяа прокурорын байгууллагад хүргүүлээд байна.

Авлигатай тэмцэх газраас төрийн өндөр албан тушаалтнуудтай үгсэн хуйвалдаж улсад онц их хэмжээний хохирол учруулсан хэрэгт М.Тулга нарын нэр бүхий 7 хүнийг яллагдагчаар татах саналыг прокурорын байгууллагад хүргүүлж, яллагдагчаар татлаа. Түүнчлэн Хөгжлийн банкны албан тушаалтнуудад холбогдох хэрэгт Эдийн засгийн хөгжлийн сайд асан Н.Батбаярыг эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татах саналыг хүргүүлсэн байна.

ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРАЛ

# ХЭЛТЭС, АЛБАДЫН ДАРГА НАР МЭДЭЭЛЭЛ ХИЙВ

## Төгсгөл. Түүрүүч нь I нүүрт

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилттэй газар дээр нь танилцах, иргэдээс гомдол мэдээлэл хүлээн авах, авлигын эрсдлийн үнэлгээ хийх, авлигын эсрэг хууль тогтоомжийн талаар сургалт зохион байгуулах, арга зүйн туслалцаа үзүүлэх зорилготой ажилласан талаар өмнөх мэдээлэлд дурдсан. Энэ ажлын хүрээнд ажлын хэсгүүдийн үзэж танилцсан материалын хувьд 2015-2016 он, 2017 оны I дүгээр улирал гэсэн цаг хугацааг хамаарч байна.

2017 оны 9 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн Төрийн албаны зөвлөл, Үндэсний аудитын газар, Авлигатай тэмцэх газар хамтран 12 яам, тэдгээрийн харьяа 20 агентлаг, 23 төрийн өмчит хуулийн этгээдэд ажилласан дүнг танилцуулсан. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Засаг даргын харьяаны агентлагууд болон 9 дүүрэгт ажилласан дүнг танилцуула. Ингэж танилцуулж байгаагийн гол ач холбогдол нь урьдчилан сэргийлэх ажлыг богино хугацаанд бага хүчээр зохион байгуулсанд оршино. Сангийн яамны хувьд улсын төсвийн асуудал УИХ-д хэлэлцэгдэж байгаагай холбоотойгоор түр хойшлогоод байна.

Ажлын хэсгүүд ажиллах явцад төрийн албан хаагчдыг ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг зөрчиж томилдог, хуульд заасан хугацаанд хөрөнгө орлогын мэдүүлгээ гаргадаггүй, хуульд заагаагүй төлбөр хураамжийг албан тушаалтнуудын тушаал, шийдвэрээр тогтоодог, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчиж худалдан авалт, тендер сонгон шалгаруулалт зохион байгуулдаг, үнэлгээний хорооны үйл ажиллагаа хууль зөрчсөн, зарим албан тушаалтны үзэмжээр худалдан авалт зохион байгуулдаг, төсөвт өрггийг нэмэгдүүлж төсвийн үр ашигтай байх зарчмыг зөрчиж худалданавалтхийдэг, тодорхой хэдэн компани аж, ахуйн нэгжийг сонгон шалгаруулалтад оролцуулдаг, Төсвийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг зөрчиж албан хаагчиддаа урамшуулал хавтгайруулан олгодог, үйл ажиллагаандаа дагаж мөрдөж байгаа дүрэм, журам нь холбогдох хуулийн заалт зөрчсөн, үндэслэлгүй төлбөр хураамж тогтоосон, аливаа зөвшөөрөл олгохдоо

хуульд заагаагүй бичиг баримт нэхдэг, хүнд суртал үүсгэдэг, дотоод хяналтын үйл ажиллагааг хангалттай хэрэгжүүлдэггүй, албан хаагчиддаа хариуцлага тооцдоггүй зэрэг зөрчлүүд илэрсэн.

Ажлын хэсгүүд газар дээр нь шууд таслан зогсоох, арилгах боломжтой зөрчлүүдийг тухай бүр арилгуулж ажилласан. Харин хууль, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, авлигын эрсдэл бий болгож буй шалтгаан нөхцлийг арилгах чиглэлээр Засгийн газар, холбогдох яам, агентлагт зөвлөмж хүргүүлнэ.

Тухайлбал, “Мэдээлэл холбооны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компани 2015 онд 2,2 тэрбум, 2016 онд 2,7 тэрбум, 2017 оны I дүгээр улиралд 381 сая төгрөгийн ажилчдаа урамшуулахад зарцуулсан байна. Урамшуулалд зарцуулж байгаа төсөв нь зарим байгууллагын бүтэн жилийн төсөвтэй тэнцэхүйц хэмжээнд байна.

Тус газар нь Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д заасан “төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх”, мөн УИХ-ын 2016 оны 51 дүгээр тогтоолоор баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (АТҮХ)-ийн 2 дугаар зорилт буюу “Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлэх, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх” ажлыг хэрэгжүүлэх хүрээнд АТҮХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.2.5-д заасан “Төрийн үйлчилгээний шударга, ил тод, нээлттэй байдлын талаарх судалгааг тогтмол хийж, үр дүнг нь үйл ажиллагаандаа ашиглах” чиг үүргийг тус тус хэрэгжүүлж байна. Энэ чиг үүргийн хүрээнд судалгаа зохион байгуулахад төрийн байгууллагуудаас үйлчилгээ авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын талаарх мэдээлэл шаардлагатай байгаа бөгөөд эхний ээлжинд аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийн нэгжээс үзүүлж буй үйлчилгээ болон уг үйлчилгээг авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын мэдээлэлтэй газар дээр нь ирэх саруудад танилцаж ажиллана.

**Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар**  
**Х.Хашбаатарын хийсэн мэдээлэл**

*1. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн хяналтын талаар:*

2017 оны 9 дүгээр сарын 25-наас 10 дугаар сарын 24-ний өдрийг хүртэлх хугацаанд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 1029 этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хүлээн авснаас 821 этгээдийн урьдчилсан мэдүүлгийг хянан шийдвэрлэлээ. Цагдаагийн ерөнхий газар, Зэвсэгт хүчний жанжин штаб, Оюуны өмч, улсын бүргэлийн ерөнхий газраас хамгийн олон мэдүүлэг хянуулахаар ирүүлжээ.

Эдгээрээс илт зөрчилтэй 2 иргэний тухай танилцуулбал:

\*Нийслэлийн Хот төлөвлөлт Ерөнхий төлөвлөгөөний газрын ерөнхий архитекторын ажлын албанд томилогдохоор нэр дэвшсэн иргэн Б нь ажлын байрны тодорхойлолтын ерөнхий шаардлагыг хангахгүй, мөн барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг .... ХХК-ийн үүсгэн байгуулагч, 100 хувь эзэмшигч, захирлаар бүртгэлтэй байгаа нь эрхлэх асуудлын хүрээнд албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд ашиг сонирхлын зөрчил үүсч болох нөхцөл байдал тогтоогдсон тул Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7 дахь хэсэгт заасныг хэрэгжүүлж ажиллах талаар Нийслэлийн Хот төлөвлөлт Ерөнхий төлөвлөгөөний газарт хариу мэдэгдсэн.

\*Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын Завхан аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст улсын бүртгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн иргэн Д нь тус сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн үүргийг гүйцэтгэж байгаа нь Төрийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-д төрийн жинхэнэ албан хаагч "аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөр сонгогдох, аж ахуйн нэгж, нам, олон нийтийн бусад байгууллагад орон тооны албан тушаал хавсран гүйцэтгэх"-ийг хориглоно гэж заасныг зөрчих нөхцөл байдал тогтоогдож Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7 дахь хэсэгт заасныг хэрэгжүүлж ажиллах талаар Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт хариу мэдэгдсэн.

**Төгсгөл нь IV нүүрт**

# ХЭЛТЭС, АЛБАДЫН ДАРГА НАР МЭДЭЭЛЭЛ ХИЙВ

## 2. Өргөдөл, гомдол, мэдээллийн хяналт шалгалтын талаар:

Албан тушаалтны ашиг сонирхлын зөрчилтэй эсхийг шалгуулахаар хандсан нийт 100 өргөдөл, гомдол, мэдээллийг шалгаж байна. Тус хэлтэст ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийг агуулгын хэлбэрээр нь нь авч үзвэл: Албан тушаалын байдлаа ашиглан өөртөө болон бусад давуу байдал олгосон, Албан үүргээ гүйцэтгэхдээ ашиг сонирхлын зөрчил гаргаж, албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн, Ашиг сонирхлын зөрчилтэй хууль бус томилгоо, шийдвэр гаргасан талаарх асуудал дийлэнх хувийг эзэлж байна. Орхон, Баянхонгор, Дундговь аймгуудаас ирүүлсэн өргөдөл, гомдол бусад аймгуудтай харьцуулахад өндөр дүнтэй байна.

Дээр дурдсан шийдвэрлэсэн 11 өргөдлөөс зөрчилтэй байсан өргөдлийг дурдвал:

\*Баянзүрх дүүргийн ... дугаар цэцэрлэгийн эрхлэгч Д нь хууль бус төлбөр хураамж авсан, өөрийн хамаарал бүхий этгээдийг ажилд авсан ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол мэдээллийн дагуу хяналт шалгалт явуулхад Нийтийн болон нийтийн албанд хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн "Албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалт"-ыг зөрчсөн болох нь тогтоогдсон тул хариуцлага тооцуулахаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболдод албан бичиг хүргүүлсэн.

\*Өмнөговь аймгийн ... сумын ЕБС-н захирал А нь хамаарал бүхий этгээдтэй холбоотой шийдвэр гаргасан, хууль бус үйлдлийг шалгуулах тухай гомдол мэдээллийн дагуу хяналт шалгалт явуулахад А нь хамаарал бүхий этгээдтэй хувийн ашиг сонирхлыг хөндсөн шийдвэр гаргасан нь тогтоогдсон түүнд тул аймгийн Засаг даргын захирамжаар цалингийн хэмжээг 1 сарын хугацаагаар 30 хувиар бууруулах сахилгын шийтгэл тооцуулсан.

*3. Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн хяналт шалгалтын талаар:*

Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэгт заасан төлөвлөгөөт хяналт шалгалтын хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Эрүүл, мэнд нийгмийн даатгалын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Татварын ерөнхий газар зэрэг байгууллагын холбогдох албан тушаалтнуудын хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгаж байна.

Хяналт шалгалтаар хөрөнгө, орлогын мэдүүлгээ зөрчилтэй мэдүүлсэн Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны 7, Оюуны өмч улсын бүртгэлийн ерөнхий газрын 4 албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар тухайн байгууллагын удирдлагуудад албан бичгийг хүргүүлээд байна. Үүнд: Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга зэрэг 7 албан тушаалтан, Оюуны өмч улсын бүртгэлийн ерөнхий газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод



аудитын газрын дарга зэрэг 4 албан тушаалтан.

Мэдүүлэг гаргагч нар нь өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлого болон түүнд орсон их хэмжээний өөрчлөлтийг хуульд заасан хугацаанд мэдүүлээгүй, цалингийн орлогыг гарт олгосон дүнгээр мэдүүлэх, гэр бүлийн гишүүдийн дундын өмчлөлийн үл хөдлөх хөрөнгө, мөн хөрөнгө оруулсан аж ахуйн нэгж байгууллага, хувьцааг мэдүүлээгүй, харилцах данс, картын данс, бэлэн мөнгөний үлдэгдлийг оны эцсийн үлдэгдлээр бус мэдүүлэг гаргах үеийн байдлаар мэдүүлсэн зэрэг нийтлэг зөрчлүүдийг гаргасан байна.

## Мөрдөн байцаах албаны дарга, ахлах комиссар Н.Дамдинсүрэнгийн хийсэн мэдээлэл

Мөрдөн шалгах хэлтсээс өнгөрсөн сард хэрэгжүүлсэн ажлаа тоон үзүүлэлтээр мэдээлье. 2017 оны 10 сарын байдлаар Мөрдөн шалгах хэлтэс нь нийт 68 гомдол, мэдээллийг шалгасан. Үүнээс 17-д нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн, 24 гомдолд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан, 7 гомдлыг харьяаллын дагуу шилжүүлсэн, 2 гомдлыг өөр хэрэгт нэгтгэсэн, одоогоор 18 гомдлыг ажиллагаанд шалгаж байна.

Нийт сарын хугацаанд 155 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан. Үүнээс 12 хэргийг шүүхэд шилжүүлсэн, 12 хэргийн хэрэг бүртгэлтийг хаасан, 4 хэргийг нэгтгэсэн, одоогоор ажиллагаанд 127 хэрэг шалгагдаж байна.

Хэрэгт холбогдон шалгагдсан хүмүүсийг албан тушаалын байдлаар нь ангилж үзэхэд, шүүхэд шилжүүлсэн 12 хэрэгт холбогдсон 36 хүний 8 нь улс төрийн албан тушаалтан, төрийн захиргааны албан тушаалтан 7, төрийн тусгай албан тушаалтан 11, бусад 16 хүн байна.

Дээрх 12 хэргийг зүйл, ангиар нь ангилахад 8 нь буюу 66.6 хувь нь албан тушаалын гэмт хэрэг, 4 буюу 35.4 хувь нь бусад гэмт хэрэг байна. Шүүхэд шилжүүлсэн 12 гэмт хэргийн улмаас улсад 9.1 тэрбум төгрөгийн хохирол учирсан.

Өмнөх оны мөн үетэй харьцуулж үзсэн байдлаар танилцуулах нь зүйтэй. 2016 оны 10 сарын байдлаар Мөрдөн шалгах хэлтсээс нийт 18 хэрэг шүүхээр шийдвэрлүүлж байсан бол 2017 оны 10 сарын байдлаар энэ нь 24 болж өссөн дүнтэй байна. Мөрдөн шалгасан хэрэг өнгөрсөн оны мөн үед 213 хэрэг байсан бол энэ оны хувьд 304 болсон бөгөөд энэ нь өнгөрсөн оныхоос 42.5 хувиар өссөн үзүүлэлт юм.

Дээр нь нэг зүйл нэмж хэлэхэд, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар хүлээсэн мөрдөгчийн үүрэг бий. Гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгах чиглэлээр тухайн байгууллага, албан тушаалтанд Мөрдөн байцаагчийн мэдэгдэл хүргүүлдэг. Энэ дагуу Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөгчид нийт 14 мэдэгдлийг тухайн гэмт хэрэг гарсан байгууллагуудын удирдах албан тушаалтнууд руу хүргүүлж, гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгуулах чиглэлээр ажиллаж байна.

## ХЯНАЛТ ШАЛГАЛТ

# Яам, агентлагт ажилласан дүнг хэлэлцүүлээ

**АТГ яам, агентлагуудын авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцсан дүнгээ 2017 оны 10 дугаар сард тухайн яам, агентлагийн удирдах албан тушаалтнуудыг оролцуулан хэлэлцүүлээ. Уг хэлэлцүүлгийн мэдээллээс товчлон хүргэе. Дэлгэрэнгүй мэдээллийг [www.iaac.mn](http://www.iaac.mn) цахим хуудаснаас хүлээн авч уншина уу.**

**Эрчим хүчний яам.** Тус яамны 15 албан хаагч хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газраар хянуулалгүй томилогдсон байна. Түүнчлэн хуулиас давсан журам баталж үндэслэлгүйгээр нэмэлт төлбөр,

төгрөгийг Эрчим хүчний хөгжлийн төвийн дансанд төвлөрүүлсний дараа тусгай зөвшөөрлөө авдаг байна. Энэ нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийг зөрчсөн байна.

**Хууль зүй, дотоод хэргийн яамны** харьяанд 218 байгууллага байдаг бөгөөд тус салбар нь чиг үүргийн хувьд харьцангуй тогтвортой ажээ. Салбарын хэмжээнд сүүлийн хоёр жилийн байдлаар хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянуулж томилогдох 398 албан тушаалтны 146 нь тухайн албан тушаалд томилогдохдоо мэдүүлгээ хянуулаагүй нийтлэг зөрчил гаргажээ. Цагдаа, хил хамгаалах, шийдвэр гүйцэтгэх, гадаадын иргэн харьяатын байгууллагууд албан хаагчдад зориулсан орон суу-

хэсэг Улсын бүртгэлийн сангаас түүврийн аргаар хайлт хийхэд 80 иргэний нэр дээрх үл хөдлөх хөрөнгөд Сургалтын төрийн сантай байгуулсан барьцааны гэрээ бүртгэл байхгүй, 15 иргэний нэр дээрх үл хөдлөх хөрөнгөнд сургалтын төрийн сангийн барьцаа бүртгэлтэй, 9 иргэн сургалтын гэрээний үүргээ биелүүлсэн үндэслэлээр барьцаа хөрөнгийг чөлөөлж шийдвэрлэсэн байв. Иймд Боловсролын зээлийн сантай байгуулсан гэрээний үүргээ биелүүлээгүй, Монгол Улсад ирж ажиллаагүй иргэдийн судалгааг Боловсролын зээлийн сангаас нарийвчлан гаргаж, буруутай этгээдээр хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг шийдвэрлэж нийтэд ил тод мэдээлэх шаардлагатай гэж Ажлын хэсэг

зохицуулалтыг салбарын төрийн захиргааны байгууллага боловсруулах нь зүйтэй гэж Ажлын хэсгээс яамны албан тушаалтнуудад зөвлөлөө.

**Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны** нийт албан тушаалтнуудын давхар ажил эрхлэлтийн судалгаагаар танилцахад 2017 оны байдлаар 15 албан тушаалтан ажлын бус цагаар давхар ажил эрхэлж байв. Яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын гадаад хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн У нь БНХАУ-ын хөрөнгө оруулалттай 3 компанид зөвлөх, орчуулагчийн ажил хийдэг ажээ. Тэрээр яамны удирдах албан тушаалтнаас давхар ажил эрхлэх зөвшөөрлийг бичгээр хүссэн боловч удирдлагын



хураамж тогтоосон нь тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийг хохироож байна гэж үзэх үндэслэлтэй байна. Улсын гэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 23 дугаар зүйлд Түлш, эрчим хүчний чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураамж хураамжийн хэмжээг хатуу тогтоож өгсөн байтал Эрчим хүчний сайдын 2012 оны 64 дүгээр тушаалыг үндэслэж Эрчим хүчний хөгжлийн төвийн захирлын 2012 оны Б/36 дугаар тушаалаар “Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны үйлчилгээний үнэ тооцоо журам”-ыг батлан тусгай зөвшөөрөл олгох үндсэн нэр төрлийн суурь үнэ 100 мянган төгрөгийг Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэнгийн дансанд тушаахаар зохицуулсан байна. Мөн тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээний 6 төрлийн 26 ажилд 100 000-1 600 000

цыг барьж ашиглалтад оруулсан бөгөөд албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхдээ санхүүгийн болон хуваарилалтын асуудалд ил тод байдлыг сайжруулах шаардлагатай гэж ажлын хэсэг үзсэн байна. АТГ-ын “Төрийн байгууллагуудын шударга байдлын үнэлгээ-2016” тайланд Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлагуудын үнэлгээ улсын дунджаас дээгүүр үнэлэгдсэн байна.

**Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам.** 1997-2001 онд Боловсролын зээлийн сан / хуучин нэрээр Сургалтын төрийн сан/-гийн зээлээр гадаад улсад суралцсан боловч сургуулиа төгсөөд бүртгүүлээгүй, алга болсон нийт 344 оюутан бүртгэлтэй байх бөгөөд тэдэнд олгосон сургалтын төлбөр нь 8.3 сая ам.доллар болжээ. Дээрх 344 иргэний судалгаанаас Ажлын

үзлээ. Хэлэлцүүлгийн үеэр өндөр төлбөртэй гэж яригддаг хувийн өмчийн ЕБС-ийн сургуулиудын 2016 онд төрөөс авсан хувьсах зардлын хэмжээг Ажлын хэсэг нэгбүрчлэн танилцуулав. Боловсролын салбарын мэргэжлийн холбоодтой Ажлын хэсгийн гишүүд уулзаж ярилцахад хувийн өмчийн өндөр төлбөр авдаг ЕБС, цэцэрлэгүүдэд төрөөс хувьсах зардал олгож байгааг буруу шийдвэр, энэ их хэмжээний төсвийн хөрөнгөөр шинэ сургууль, цэцэрлэг барьж байгуулах нь зүйтэй гэсэн саналыг Авлигатай тэмцэх газарт уламжилжээ. Тиймээс хувьсах зардлын хуваарилалт, тайланд дотоодын хяналт-шинжилгээ үнэлгээ хийх, хариуцлага тооцоо механизмыг бүрдүүлэх, боловсролын салбарын санхүүжилтийн тогтолцоог илүү үр ашигтай, тэгш байдлыг хангасан, санхүүжилтийн үр дүнг тооцсон

зүгээс илтэд ашиг сонирхлын зөрчил үүсэх тул зөвшөөрөөгүй байна. Гэвч У нь удирдлагаас зөвшөөрөлөгөөгүй байхад дээрх 3 компанид давхар ажил эрхэлж байжээ. Уг асуудлыг Авлигатай тэмцэх газар хуулийн хүрээнд нарийвчлан шалгаж байна.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд иргэн, аж ахуйн нэгжээс 2016 онд нийт 700 гаруй төсөл ирүүлснээс 212-т нь зээл олгох шийдвэр гаргажээ. Шалгарсан 212 төслийн 83 төсөлд нийт 43.54 тэрбум төгрөгийн зээл олгохоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд шийдвэрлэсэн байв.

Чухам ямар шалгуур үзүүлэлтээр, юуг үндэслэж аж ахуйн нэгжүүдэд зээл олгосныг Авлигатай тэмцэх газар дахин нарийвчлан судалж, дүн шинжилгээ хийхээр болов.

**Төгсгөл нь VI нүүрт**

# Яам, агентлагт ажилласан дүнг хэлэлцүүлээ

**Төгсгөл. Түрүүч нь V нүүрт**  
Түүнчлэн Үндэсний Аудитын газраас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяа сангуудад эрсдлийн аудит хийх шаардлагатай байна гэдгийг мэдэгдлээ.

**Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам,** Ашигт малтмал газрын тосны газрын албан хаагчид ажил үүргийнхээ хажуугаар шинжээчийн үүргийг давхар гүйцэтгэж ажилладаг байна. Уул уурхайн 19 мэргэжилтэн аж ахуйн нэгжийн ашигт малтмалын ордын нөөцийг тогтоосон тайланд шинжээчээр оролцож 3-25 сая төгрөгийн хөлс авчээ. Энэ салбарт төрийн албан хаагч өөрийн эрхэлж буй ажлын хүрээнд шинжээчээр оролцож, түүнээсээ орлого олохыг зөвшөөрсөн журам үйлчилж байгаа нь авлигын маш



том эрсдэл бөгөөд төрийн албан хаагч хуулиар зөвшөөрснөөс өөр давхар ажил эрхлэхгүй байх хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн байна.

Яамны албан тушаалтнуудын зүгээс “Уул уурхайн шинжээчээр ажиллах хүн дутмаг байдаг. Энэ нь монгол мэргэжилтний үнэлэмжтэй холбоотой” гэсэн тайлбар хийж байв. Гэвч төрийн яамны бодлогыг хэрэгжүүлж байгаа мэргэжилтнүүд нь үр дүн, гүйцэтгэл шаардах ёстой аж ахуйн нэгжүүдээсээ шинжээчийн ажлын хөлс нэрээр төлбөр авч байгаа нь илт ашиг сонирхлын зөрчилтэй үйлдэл юм.

**Барилга, хот байгуулалтын яам.** Тус салбарт 2015-2017 онд томилогдсон удирдах албан тушаалтны 76 хувь нь 2016 онд буюу сонгуулийн жилийн дараа тухайн албан тушаалд томилогдсон нь боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах, төрийн жинхэнэ албан хаагчийг улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг боловсролд суурилсан мерит

зарчимд тулгуурлан томилох зарчим алдагдсан, сонгуулийн үр дүн, нам, улс төрийн нөлөөтэй гэж үзэхээр байна. Ажлын хэсэг тус яамны албан тушаалтнуудын хуулийн этгээдийн үйл ажиллагаа болон аж ахуйн нэгж байгууллага, тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн талаарх судалгааг түүвэрчилсэн байдлаар гаргаж танилцууллаа. Мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, газар, хэлтсийн дарга зэрэг 20 албан тушаалтныг хамруулан судалж үзэхэд тэдгээрийн 40.7 хувь нь барилгын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ажээ. Тэдний ердөө 9 нь аж ахуйн нэгжээ бусдад шилжүүлсэн бөгөөд ингэж шилжүүлснээр зөрчлөө арилгасан гэж үзэхгүй бөгөөд цаашлаад дээрх аж ахуйн нэгж, байгууллагатай холбоотой захиргааны акт



гаргах, гэрээ байгуулах, тендер сонгон шалгаруулах зэрэг үйл ажиллагаанд оролцохгүй байх, хуульд заасан ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд мэдэгдэл, тайлбар гаргаж байх, хуулийн шаардлагыг хэрэгжүүлж ажиллах талаар анхаарууллаа.

**Гадаад харилцааны яамны** хувьд 2015-2017 онд 74 иргэнийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн холбогдох заалтыг зөрчин хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлийг Авлигатай тэмцэх газраар хянуулалгүйгээр нийтийн албанд томилсон байна. Гадаад харилцааны яамны зарим албан тушаалтнууд албаны эрх мэдлээ урвуулан ашиг олох зорилгоор дипломат, албан паспортгүй энгийн иргэнд олгосон, дипломат паспортгоор хил нэвтэрч хууль бус наймаа (тамхи зөөх) хийж байгаад саатуулагдсан зэрэг асуудлыг ажлын хэсэг хэлэлцүүлгийн үеэр хөндөв.

Дипломат төлөөлөгчийн газрууд батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулах, зориулалтын бусаар өөр зүйлд зарцуулах, визний хураамж, нотариатын үйлчилгээгээр орсон орлогыг төрийн санд төвлөрүүлдэггүй гэсэн төсөөллийн судалгааны дүн бий. Эдгээр нь ч Үндэсний аудитын газрын дүгнэлтээр баталгаажсан болохыг ажлын хэсэг тодорхой жишээн дээр танилцууллаа.

**Эрүүл мэндийн яам** хувийн эмнэлгүүдэд магадлан итгэмжлэл олгодог бөгөөд энэ үйл ажиллагааг зохицуулсан журам нь жил бүр өөрчлөгддөг, тусгай зөвшөөрөл олгохдоо хуульд заагаагүй бичиг баримтыг иргэдээс шаардаж байгаа нь мөн хүнд суртал, чирэгдэл, авлига үүсгэх эрсдлийг бий болгож байна гэв. Магадлан итгэмжлэл



олгох шалгуур үзүүлэлтээ эргэн харах шаардлагатайг Ажлын хэсэг яамны албан тушаалтнуудад зөвлөлөө.

Тус яамны удирдлагаас 2015, 2016 онд гаргасан тушаал шийдвэрүүдийг хянан үзэхэд хэд хэдэн нийтлэг зөрчил илэрчээ. Мөн 2015 онд Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан яамны нийт албан хаагчдад хавтгайруулан 10.2 сая төгрөгийн урамшуулал олгосон нь төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээг үндэслэн шагнаж урамшуулах тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн байна. Зөвхөн хоол, унааны зориулалтаар 3.3 сая төгрөг зарцуулсан нь төсвийн хөрөнгөөр ой тэмдэглэх, арга хэмжээ зохион байгуулахгүй байхыг даалгасан Засгийн газрын тогтоолыг зөрчжээ.

**Байгаль орчин, аялал жуулчлалын яам.** Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5-д “энэ хуулийн 11 дүгээр

зүйлийн 7-д зааснаас өөр барилга байгууламж барих”, 12.9-д “өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслангийн барилга байгууламж барих, зохих зөвшөөрөлгүйгээр мал бэлчээрлүүлэх”-ийг хориглоно гэж заасан байдаг. Гэтэл дээрх хуулиар тогтоосон хамгаалалтын дэглэмийн зохицуулалтыг үл харгалзан дархан цаазат газарт иргэн, аж ахуйн нэгж байгууллага, тус байгууллагын албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх нэрийдлээр барилга байгууламж барин шугам сүлжээ татаж, суурьшлын бүс байгуулж болох мэт ойлголтыг төрүүлэн, “тусгай хамгаалалттай газар” гэх нийтлэг нэрийн дор байгалийн цогцолборт, нөөц болон дурсгалт газарт газар ашиглах зөвшөөрөл олгосон байна. Энэ нь Байгаль орчны сайдын 2001 оны 10 дугаар



сарын 28-ны өдрийн 218 дугаар тушаалаар батлагдсан “Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах зөвшөөрөл олгох түр журам”-ыг өнөөг хүртэл мөрдөж байгаатай холбоотой. Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэг хэлэлцүүлгийн үеэр улсын тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглагч иргэн, аж ахуйн нэгжийн судалгааг гаргаж танилцуулав. Улсын тусгай хамгаалалттай газар нутагт 2015-2017 онд нийт 1706, Богдхан уулын дархан цаазат газарт 1318 иргэн, аж ахуйн нэгж газар ашиглаж байна. Байгаль орчны яам дархан цаазат болон улсын тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах зөвшөөрөл олгохоор заасан аль 2001 оны журмыг яагаад одоо хүртэл мөрдсөөр байгааг хэлэлцүүлэгт оролцогчид асууж байв. Энэ хугацаанд Байгаль орчны хэд хэдэн сайд өөрчлөгдөж солигдсон ч энэ журам 17 жил түр нэртэй боловч он дамжин хэрэгжсээр байжээ. Үүнд яамны албан тушаалтнууд тайлбар өгсөнгүй.

ТОДРУУЛГА

## Т.Мөнхтунгалаг: АТГ-ын албан хаагчид Олон нийтийн дэд зөвлөлийг ажилд нь оруулна

*АТГ-ын албан хаагчид хөдөө орон нутагт ажиллаж эхэлжээ. Энэ талаар тодруулж, тус газрын Хэвлэл, олон нийттэй харилцах ажилтан, комиссар Т.Мөнхтунгалагтай ярилцав.*

**-АТГ-ын албан хаагчид ямар аймгуудад ажиллаж байна вэ? Тэд орон нутагт юу хийх вэ?**

-АТГ-ын албан хаагчид 11 дүгээр сарын 24-нийг дуустал хугацаанд бүх аймаг, зарим сумдад ажиллана. Маш товчхондоо орон нутгийн төрийн байгууллагуудын авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг газар дээр нь шалган туслах, авлигын нөхцөл байдлыг тодорхойлох зорилготой ажиллаж байна. АТГ өнгөрсөн хавар яам, агентлаг, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн 2015, 2016, 2017 оны эхний улирлын үйл ажиллагаатай танилцаж, тайлан дүгнэлтээ саяхан хэлэлцүүлж дууссан. АТГ төрийн байгууллагуудад ажиллахдаа хүний нөөцийн бодлогын хэрэгжилт, албан тушаалын томилгоо, иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, тухайн байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийн агуулга, шийдвэрлэлт, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа зэрэг үйл ажиллагаатай танилцаж, судлан, санал дүгнэлт гаргаж байгаа. Энэ бүх асуудлыг орон нутагт ч мөн хэрэгжүүлнэ. Түүнээс гадна “Авлигаас урьдчилан сэргийлэх Олон нийтийн дэд зөвлөл”-ийн гишүүдийг сонгож, ажилд нь оруулна.

**-Та жаахан тодруулахгүй юу. Хүний нөөцийн бодлогын хэрэгжилт, төрийн үйлчилгээний чанар, хүртээмж гэхээр юуг шалгана гэсэн үг вэ?**

-Хүний нөөцийн бодлогын хэрэгжилт гэхэд л боловсон хүчний томилгоог яаж хийсэн бэ, байгууллагад бүтцийн өөрчлөлт хийхдээ хэчнээн хүнийг төрийн албанаас халсан, чөлөөлсөн бэ, тэдгээрээс хэдийг ажилд нь эгүүлэн томилсон бэ, үүнээс үүсэх эдийн засгийн үр дагавар нь ямар байв,

үндэслэлгүй ажлаас чөлөөлөгдсөнөөс хэдий хэмжээний нөхөн төлбөр төсвөөс төлөгдсөн бэ, байгууллагын албан хаагчид давхар ажил эрхэлдэг үү, ажилтнуудын нийгмийн асуудлыг хэрхэн шийдвэрлэдэг вэ гэх мэт асуудлыг нарийвчлан үзэж танилцана. Бас төрийн үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдалтай танилцахдаа хүнд суртал, чирэгдэл үүсгэж байгаа хууль тогтоомж, дүрэм журам юу байна, цахим үйлчилгээ үзүүлдэг үү, тусгай зөвшөөрөл, эрх олгох, бүртгэл хийх, хяналт тавих үйл ажиллагаа нь ямар шатанд байна вэ, үндэслэлгүй төлбөр хураамж, хандив, тусламж авдаг уу зэрэг асуудлыг хянан үзэх гэх мэтээр нарийвчлан задалж авч үзэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх юм.

**-Шалган туслах гэхээр ямар ажил юм бэ? Хяналт шалгалтын ажил биш юм уу?**

-Шалган туслах гэдэг нь илэрсэн зарим алдаа, зөрчил, дутагдлыг газар дээр нь арилгуулж, дахин давтан гаргуулахгүй байх үүднээс заавар зөвлөгөө өгч ажиллана гэсэн үг. Шууд утгаараа хяналт шалгалтын ажил гэж ойлгох нь өрөөсгөл. Гэхдээ авлига, ашиг сонирхлын зөрчлийн эсрэг хууль тогтоомжийг төрийн байгууллагууд хэрхэн хэрэгжүүлж байгааг шалгаж, авлигын нөхцөл байдал, эрсдлийг тодорхойлж, авлига үүсэх нөхцөл шалтгааныг арилгах нь бидний ажлын гол зорилго.

**-Олон нийтийн дэд зөвлөлийг ажилд нь оруулна гэдгээ тодруулаач?**

-УИХ-аар батлагдсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт аймаг, нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дэргэд “Авлигаас урьдчилан сэргийлэх Олон нийтийн дэд зөвлөл” ажиллахаар тусгасан. Энэ дагуу аймаг бүрт ажиллах Олон нийтийн дэд зөвлөлийн 3 гишүүний сонгон шалгаруулалтыг АТГ өнгөрсөн оны 11 дүгээр сард явуулсан юм. Одоо тэдгээр шалгарсан иргэдтэй гэрээ байгуулж, орон



нутгийнхаа төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих ажлыг эхлүүлнэ.

**-АТГ-ын албан хаагчид орон нутагт очиж ажилласны үр дүн хэзээ хэрхэн гардаг вэ?**

-АТГ орон нутагт салбаргүй байгууллага. Авлигаас урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх, албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах ажлыг улсын хэмжээнд удирдан зохион байгуулдаг. Орон нутгийн иргэдээс авлига, албан тушаалын гэмт хэргийн шинжтэй өргөдөл, гомдол, мэдээлэл нэлээд ирүүлдэг. Энэ хүрээнд АТГ-ын албан хаагчид тухайн аймаг, суманд томилолтоор очиж ажиллаж, үүрэг гүйцэтгэх ажиллагаа тасралтгүй хийгдсээр байгаа. АТГ-ын ажлын үр дүнг зөвхөн орон нутагт гэлгүй улсын хэмжээнд нийт төрийн байгууллагад очиж, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянан ажиллаж байгаагаар дүгнэх боломжтой. Энэ 11 дүгээр сараас эхлэн аймаг бүрт 3 гишүүнтэй Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хүрээнд байгуулагдаж байгаа Олон нийтийн дэд зөвлөл ажиллана. Төрийн байгууллагын үйл ажиллагааг иргэд хянаж эхэлнэ гэсэн үг. Тэгэхээр авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын үр дүн өмнөхөөс илүү сайжирна гэдэгт бүрэн итгэлтэй байна.

# АТГ-ын тухай хэвлэлд...

## Яамдууд АТГ-т гэдэс дотроо уудлуулж байна

Ойрд яамдын төрийн нарийн бичгийн дарга нар АТГ руу нэг нэгээрээ дуудагдан гүйлдэх болов. Засаг солигдох энэ торгон мөчид АТГ-ын урилгыг авсан төрийн нарийн бичгийн дарга нар тэвдүүхэн байгаа бололтой.

АТГ өнгөрсөн хавар бүх яам, агентлагт шалгалт оруулжээ. Энэ шалгалтаар хүний нөөц, боловсон хүчний томилгоо, халаа ээлгээ, дарга нарын тушаал шийдвэр, мөнгө санхүүгийн захиран зарцуулалт, тендер сонгон шалгаруулалт, худалдан авах ажиллагаа гээд бүх бичиг баримттай нь танилцсан байна. Үндсэндээ бол хамаг л гэдэс дотроо уудлуулсан байна. Шалгалтын дүнгээ дараа нь хэлэлцүүлэх гэтэл сонгууль давхцаад, төдөлгүй улсын баяр наадам, зуны их амралт таараад хойшлуулсаар өнөөг хүргэсэн аж. Шинэ Ерөнхий сайд, шинэ Засгийн газар, шинэ бүрэлдэхүүнд АТГ яам, агентлагийн өмнөх алдаа, дутагдал, зөрчлийг нь хэлж өгөхөөр ажиллаж байгаа нь харин ч цагаа олсон байж мэдэх юм. АТГ-ын шалгалтаар олон тооны ноцтой зөрчил илэрсэн байна.

Илэрсэн зарим зөрчлийг АТГ эрүүгийн хэрэг үүсгүүлэхээр шилжүүлж, зориулалтын бусаар зарцуулсан мөнгийг буруутай этгэдээр буцаан төлүүлэх, хууль бус шийдвэрийг цуцлуулах, сахилгын хариуцлага тооцуулах, зөрчлийг дахин гаргуулахгүй байх талаар Төрийн нарийн бичгийн дарга нарт хатуухан анхааруулга өгч байна.

## АТГ тендерийн хар жагсаалт гаргана

АТГ-ын дарга Х.Энхжаргал шинээр томилогдсон Олон нийтийн зөвлөлийн гишүүдтэй уулзах үеэрээ хар жагсаалтын талаар ярьжээ. Олон нийтийн зөвлөлийн гишүүн Бямбацэрэн “Авлигын эсрэг хууль тогтоомжийг сайжруулах чиглэлээр танай байгууллага ямар санал санаачилга гаргасан бэ?” гэж асуусан байна. Энэ асуултад АТГ-ын дарга Х.Энхжаргал хариулахдаа, бидэнд олон төрлийн санаа санал байгаа. Өмнөх Олон нийтийн зөвлөлөөс саналыг нь авч байсан. Одоо та бүхнээс ч санал авна. Бид их олон зүйл санаачилж хийе гэж байгаа. Жишээлбэл, хар жагсаалт байна гэжээ.

Сангийн яамнаас төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаатай холбогдуулан хар жагсаалт буюу BLACK LIST гаргасан боловч үүнийх нь хугацаа дуусаад нэлээд удаж байгаа юм байна. Одоогоор энэ хар жагсаалтад 170 гаруй байгууллага байдаг ажээ. АТГ-ын даргын хэлснээс үзвэл, хар жагсаалтад зөвхөн аж ахуйн нэгж, компанийг оруулах нь хангалтгүй юм байна. Өөрөөр хэлбэл, төрийн байгууллагад тендер сонгон шалгаруулахад АЗ сертификаттай хүн заавал оролцдог, тэр хүний шалгаруулсан тендер, худалдан авах ажиллагаа будилаантай байх юм бол тэр хүнийг хар жагсаалтад оруулдаг болгох аж. Аль нэг аймаг, яам, агентлагийн тендер, худалдан авах ажиллагаанд тэр хүн дахиж орох эрхгүй байхаар журмыг нь өөрчлөх саналыг АТГ-ын дарга гаргаад байгаа юм байна.

## АТГ багийн зохион байгуулалтаар ажиллаж байна

АТГ-ын албан хаагчид 7 багт хуваагдан ажиллаж байна. Авлигын эсрэг хуульд зааснаар АТГ нь урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, хяналт шалгалт дүн шинжилгээ, мөрдөн шалгах, гүйцэтгэх ажил гэсэн чиг үүргүүдийг хэрэгжүүлэх бөгөөд энэ чиг үүргийнхээ дагуу 5 хэлтэст хуваагддаг юм.

Харин АТГ-ын даргын тушаалаар дээрх 5 хэлтсийн албан хаагчдаа 7 багт хуваажээ. Нэг багт авлигаас урьдчилан сэргийлэх болон соён гэгээрүүлэх чиглэлийн мэргэжилтнүүд, мөрдөн байцаагч нар, хяналт шалгалтын албан хаагчид, гүйцэтгэх ажилтнууд орж байгаа юм байна. Ингэснээр ямар нэгэн төрийн байгууллага руу хяналт шалгалтаар ороход бүх талаас нь үзэж танилцах боломжтой болж байгаа аж. Өөрөөр хэлбэл, зөрчил илэрлээ гэхэд урьдчилан сэргийлэх чиглэлийн ажилтнууд нь уг зөрчил үүссэн шалтгаан, нөхцөлийг нь тогтоож, арилгах, дахин гаргуулахгүй байх чиглэлээр хамтран ажиллах юм. Соён гэгээрүүлэх ажилтнууд нь хууль тогтоомжийг таниулах, авлигын аливаа эрсдэлд өртөхгүй байх чиглэлээр сургалт хийдэг байна.

Мөнөөх зөрчилд эрүүгийн гэмт хэргийн шинж байгаа эсэхэд мөрдөн байцаагч нар нь дүгнэлт хийж, гүйцэтгэх ажилтнууд нь хуульд заасан арга хэмжээг авч хэрэгжүүлдэг аж. Харин хяналт шалгалтын албан хаагчид иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээлэл болон албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг нь хянан шалгах зэргээр ажиллаж байна. Тус байгууллагын багаар ажилласан анхны тохиолдол нь яам, агентлагуудыг шалгасан явдал юм. Багууд шалгасан яам, агентлагуудаа хэлэлцүүлж байгаа билээ. АТГ-ын багуудыг хэлтэс, албадын дарга нар нь удирдаж байгаа бөгөөд ийнхүү багт хувааснаар байгууллагын дотоодод багаар ажиллаж сурах, албан хаагчдыг хөгжүүлэх, авлигатай тэмцэх ажлын үр дүнг дээшлүүлэх зэрэг ач холбогдолтой ажил болж байгаа ажээ.

